



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/1404

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 104 дүгээр сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Эцэг эхчүүдээс хандивласан нийт 10,000,000.00 (арван сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 104 дүгээр сургууль (Б.Бадамханд)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 104 дүгээр сургууль (Б.Бадамханд)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
 2025 оны 09 дүгээр сарын 10-ны
 өдрийн А/УОХ дугаар тушаалын хавсралт



Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 104 дүгээр сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ		Хандив	
						Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Контейнер /агуулах/	2025.08.18	сайн	ш	1	10,000,000.00	10,000,000.00	эцэг эхчүүд	Хандив
Бүртгэх хөрөнгийн нийт дүн							10,000,000.00		